



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БАЙГАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙН
ЗАРЦУУЛАЛТ, АНГИЙН ОРЛОГО, ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ
АШИГТ МАЛТМАЛЫН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ

АУДИТЫН КОД: БНА-2020/07/-НА

Баянхонгор хот 2020 он

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**

Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер А.Цэням

Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Азбаяр

Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn

Аудитор Б.Цэрэнчимэд

Утас: 88117644 цахим хуудас: tsrenchimedb@audit.gov.mn

Аудитор Н.Бүнчинсүрэн

Утас: 99049866 цахим хуудас: bunchinsurenn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН	6
БҮЛЭГ 1. Ангийн орлогын төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үйл явц хуульд нийцэж байна уу?	6
<i>А.1. Баянхонгор аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт байгалийн нөөц ашиглах талаар заалт тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцож ажилласан байна.</i>	6
А.2 Ангийн төлбөрийн орлогын ногдуулалтыг хийсэн акт үйлдэж тооцоо нийлээгүйгээс орлогын зөрүүг аудитаар нотлох боломжгүй байна.	7
А.3. Сумдын ЗДТГ нь Төрийн санд төвлөрсөн орлогын дүнгээр ангийн төлбөрийн орлогын тайланг татварт тайлагнасан байна.	11
А.4 Ангийн төлбөрийн орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага албан тушаалтан хуулийн дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.	12
БҮЛЭГ 2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт нь хуульд нийцэж байна уу? 12	
Б.1 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, төлбөр төлөхтэй холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байна.	12
Б.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 18 хуулийн этгээдэд олгосон хэдий ч ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэг ч аж ахуйн нэгж байхгүй байгаа нь хууль зөрчигдөх гол шалтгаан болж байна.	13
Б.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогыг төлөвлөхдөө бодитой төлөвлөөгүйгээс бүрэн төвлөрүүлээгүй байна.	14
<i>Б.4. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох болон төлбөр төлөх үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна.</i>	18
БҮЛЭГ 3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, зарцуулж, тайлагнаж байна уу?	19
В.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг батлахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээг баримтлахгүй байна.	20
В.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдаж буй хөрөнгийн зарим хэсэг нь зориулалт бусаар зарцуулагдсан байна.	21
В.3 Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй байна.	22
АУДИТЫН ДҮГНЭЛТ:	24
6. Ангийн төлбөрийн орлогын ногдуулалтыг хийсэн акт үйлдэж тооцоо нийлээгүйгээс орлогын зөрүүг	24
АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:	25



Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү, Төрийн сангийн хэлтэс
БОАЖГ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
ТУБ	Татварын улсын байцаагч
ТТАМ	Түгээмэл тархацтай ашигт малтмал
БОНСАХЗ	Байгаль орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардал



Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт № 1	Баянхонгор аймгийн 2016-2019 оны ангийн орлогын төлөвлөлтийн байдал:	7
Хүснэгт № 2	Ангийн зөвшөөрлийн болон агнасан ангийн тоо	8
Хүснэгт № 3	Ангийн орлогын гүйцэтгэл	8-9
Хүснэгт № 4	Шонхор шувууны 2016-2019 онд барьсан тоо, төлбөрийн судалгаа	9
Хүснэгт № 5	УТХО-аар 2016-2019 онд хэрэгсэн ТАХ-ний тоо	13
Хүснэгт № 6	ТТАМ-ын албан татварын биелэлт	15
Хүснэгт № 7	Байгаль орчин нэхэн сэргээх арга хэмжээнд батлагдсан төлөвлөгөө	17
Хүснэгт № 8	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт	18

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	ТТАМ-ын төлбөрийн орлогын төлөвлөгөө	12

Хавсралтын товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд ТАХ-ний ТТАМ-ын хэрэгцээний судалгаа	
Хавсралт №2		



	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Аудит хийх үндэслэл, бүрэн эрх Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 тоот тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний 2.9, 2.22 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийв Аудитын зорилт “Байгалын нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын бүрдүүлэлт” хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг шалгаж, аудитын дүн, дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ, холбогдох байгууллагад танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Үүнд : Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэнэ. Үүнд: ➢ Ангийн орлогын төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үйл явц хуульд нийцэж байна уу? ➢ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт нь хуульд нийцэж байна уу? ➢ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, зарцуулж, тайлагнаж байна уу? Аудитын хамарсан хүрээ Аудитаар ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын бүрдүүлэлт, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зарцуулалтыг 2016-2019 онуудыг хамруулан мэдээ, тайлан, гэрээ, Төрийн сангийн хуулга холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв. Аудитын хязгаарлалт Ус, рашааны төлбөрийн орлого хамаарахгүй. Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, АДБОУС 400, АДБОУС 4000-4200 дугаар стандартууд, Монгол Улсын Төрийн аудит MNS6817:2020 стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, МУЕА-ын 2016 оны А/146 тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын түр журам”-ыг баримтлан аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн мэргэжилтнүүд, МХГ-ын Улсын байцаагч, Татварын хэлтэс, БОАЖГ-ын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах байгалийн нөөц ашигласны төлбөрийн зарцуулалт, ангийн орлого, түгээмэл тархацтай ашигт малтмалын орлого болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. ➢ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль ➢ Төсвийн тухай хууль ➢ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль ➢ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль ➢ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль ➢ Байгаль орчныг хамгаалах тухай хууль ➢ Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль ➢ Байгалын нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
--	--



**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

- Засгийн газрын 2014 оны 43 тоот тогтоолоор баталсан “ Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах” журам
- Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Үнэлгээ, төлбөр, хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай”

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат удирдаж, аудитын менежер А.Цээням чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Цэрэнчимэд, Н.Бүнчинсүрэн нар хамтран гүйцэтгэв.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2020 оны 05 дугаар сарын 21-нд эхлүүлж, талбарын ажлыг 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хүртэл гүйцэтгэж аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдөр аймгийн ИТХ, Аймгийн Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл бэрхшээл

1. Угалз, Тэх, Халиун буга агнасан гэрээ, тооцоо хийсэн акт, хяналт тавьсан тайланг ирүүлээгүй.
2. Дэлхий нийтийн цар тахал, УИХ-ын сонгуулийн сурталчилгааны ажил давхацсан зэргээс бүх сумдаар томилолтоор ажиллах боломжгүй байдал үүссэн тул ажлын баримтыг цахимаар цуглуулах шаардлага үүссэн.
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын гэрээг ашиглагч нартай байгуулаагүйгээс хэдий хэмжээний элс, хайрга олборлох эсэх нь тодорхойгүй.
4. Төсөвт өртөг бүхий зам, барилга угсралтын ажлаас ТТАМ-ын шаардлагатай тоо хэмжээг түүвэрлэхэд төвөгтэй, цаг хугацаа шаардсан зэрэг хүндрэл бэрхшээлтэй асуудлууд аудитын хугацаанд тулгарч байв.



НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

БҮЛЭГ 1. Ангийн орлогын төлбөрийг ногдуулах, түүнийг төсөвт төвлөрүүлэх, тайлагнах үйл явц хуульд нийцэж байна уу?

Ангийн орлогын ногдуулалтад тавих хяналт сул байгаагаас төлбөр тооцсон акт үйлдээгүй, төлбөрийн орлого зөрүүтэй төвлөрсөн байна.

1.1. Баянхонгор аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт байгалийн нөөц ашиглах талаар заалт тусгагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

1.1.1. Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод 3-р бүлэгт Хөдөө аж, ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлалыг хослуулсан кластер-Хонгор нутгийн ирээдүй бүлэгт “Ховор нэн ховор амьтан ургамлыг сэргээн нутагшуулах, гений санг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх аймгийн бодлогыг тодорхойлж, гадаад орон, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрт хамруулах” гэж ан, амьтны талаар авч хэрэгжүүлэх бодлогыг тусгасан байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн 2 дугаар бүлгийн 76-д “Түгээмэл тархацтай ашигт малтмалын ордуудыг эргэлтэд оруулж, керамик, полимер чулуун эдлэлийн үйлдвэр байгуулж бүс нутгийн хэрэгцээг хангах”, 4 дүгээр бүлгийн 118-д “Нэн ховор болон ховордсон амьтан, ургамлыг сэргээн нутагшуулах, тарималжуулах, зориудын аргаар үржүүлэх, гений санг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ” гэж тусгасан байна.

Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу жил бүр аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж биелэлтийг тооцож ирсэн байна. Тухайлбал:

Баянхонгор аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт байгалийн нөөц ашиглах талаар тусч байгаа бөгөөд хэрэгжилтийг тооцсон боловч тоо хэмжээний болон зарцуулсан зардлын гүйцэтгэлийг дүгнээгүй байна.

1.1.2. Санхүү төрийн сангийн хэлтэс нь ангийн төлбөрийн орлогын төлөвлөлтийн задаргааг 2016, 2017 онд архивын нэгжид олдохгүй байгаа гэсэн тайлбарыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн холбогдох мэргэжилтэн өгсөн тул хийж буй төлөвлөлтийн материалыг иж бүрэн гаргаж, архивын нэгж үүсгэж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-ын даргад зөвлөв.



Аудитаар 2018, 2019 оны ангийн орлогын төлөвлөлтийн материал болон БОАЖЯ-ны ан, агнуурын зөвшөөрлийн талаар гаргасан 2015.12.30-ны А/446, 2016.12.27-ны А/149, 2017.12.26-ны А/370, 2018.12.28-ны А/541 тоот тушаалуудыг авч, ангийн орлогын тооцооллыг хийв.

Аймгийн хэмжээнд ангийн орлогын төлөвлөлтийг олгосон зөвшөөрөлтэй харьцуулан тооцоход 2016 онд 599.9 сая 2017 онд 134.3 сая 2018 онд 113.3 сая, 2019 онд 165.4 сая төгрөгийн зөрүүтэй төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2¹ дахь заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт № 1 Баянхонгор аймгийн 2016-2019 оны ангийн орлогын төлөвлөлтийн байдал:

Сумын нэр	2016 он			2017 он			2018 он			2019 он		
	Ангийн зөвшөөрлөөр төлөвлөвөл зохих	Төлөвлөсөн дүн	Зөрүү	Ангийн зөвшөөрлөөр төлөвлөвөл зохих	Төлөвлөсөн дүн	Зөрүү	Ангийн зөвшөөрлөөр төлөвлөвөл зохих	Төлөвлөсөн дүн	Зөрүү	Ангийн зөвшөөрлөөр төлөвлөвөл зохих	Төлөвлөсөн дүн	Зөрүү
Баацагаан	46.3	6.9	(39.4)	71.1	67.2	(4.0)	20.5	58.1	37.6	70.4	68.3	(2.1)
Баянбулаг	25.6	-	(25.6)	19.2	7.1	(12.1)	115.2	11.0	(104.2)	42.1	13.5	(28.6)
Баянговь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянлиг	12.8	-	(12.8)	-	-	-	-	-	-	-	-	-
Баян-Овоо	32.0	3.0	(29.0)	108.8	87.0	(21.8)	44.8	53.0	8.2	32.0	19.2	(12.8)
Баян-Өндөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянхонгор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Баянцагаан	27.0	2.0	(25.0)	81.3	79.4	(1.9)	87.3	45.5	(41.8)	70.4	48.0	(22.4)
Богд	54.0	2.0	(52.0)	29.4	8.4	(21.0)	36.8	-	(36.8)	-	-	-
Бөмбөгөр	-	-	-	-	-	-	13.7	45.3	31.6	5.5	6.5	1.0
Бууцагаан	38.4	2.0	(36.4)	-	6.5	6.5	26.5	16.5	(10.0)	11.0	13.0	2.0
Галуут	120.6	21.4	(99.2)	71.9	47.8	(24.1)	54.7	62.8	8.1	73.1	62.0	(11.1)
Гурванбулаг	25.6	-	(25.6)	-	4.1	4.1	-	-	-	25.6	-	(25.6)
Жаргалант	-	3.0	3.0	32.0	33.1	1.1	13.7	12.2	(1.5)	16.5	13.0	(3.5)
Жинст	64.4	2.0	(62.4)	46.3	29.7	(16.7)	50.5	40.0	(10.5)	40.7	48.0	7.3
Заг	76.8	3.0	(73.8)	19.2	16.4	(2.8)	25.6	18.0	(7.6)	-	-	-
Өлзийт	86.0	3.0	(83.0)	54.2	22.0	(32.2)	25.6	29.0	3.4	66.3	48.0	(18.3)
Хүрээмарал	-	3.0	3.0	25.6	25.6	-	6.4	16.5	10.1	51.2	-	(51.2)
Шинэжинст	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Эрдэнэцогт	44.8	3.0	(41.8)	19.2	9.6	(9.6)	-	-	-	-	-	-
Дүн	654.2	54.3	(599.9)	578.3	444.0	(134.3)	521.3	408.0	(113.3)	504.9	339.5	(165.4)

Ангийн орлогыг зөрүүтэй төлөвлөгдөж байгаа дээрх зөрчил нь Монгол улсын Засгийн газрын болон БОАЖЯ-ны тухайн жилд тусгай зөвшөөрлөөр ан агнах, барих зөвшөөрлийг жил бүрийн 12 сарын 20-ноос хойш гаргаж байгаатай холбоотой байна.

1.2 Ангийн төлбөрийн орлогын ногдуулалтыг хийсэн акт үйлдэж тооцоо нийлээгүйгээс орлогын зөрүүг аудитаар нотлох боломжгүй байна.

1.2.1. Монгол улсын Засгийн газрын 2015 оны 463 дугаар тогтоолоор угалз 60, тэх 70, халиун буга 30, Засгийн газрын 2016 оны 155 дугаар тогтоолоор 2017 онд угалз 68, тэх 75, халиун буга 32, Засгийн газрын 2017 оны 338 дугаар тогтоолоор 2018 онд угалз 65, тэх 75 халиун буга 35, Засгийн газрын 2018 оны 367

¹ ... дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх.



дугаар тогтоолоор 2019 онд угалз 86, тэх 95, халиун буга 40 толгойг тус тус агнуулах зөвшөөрөл олгосон байна.

Засгийн газрын дээрх тогтоолын дагуу Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны А/446 дугаар тушаал, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны А/149 дүгээр тушаал, 2017 оны А/370 дугаар тушаал, 2018 оны А/541 дүгээр тушаалуудаар тусгай зориулалтын болон ахуйн зориулалтаар агнах амьтны тоог аймаг сумын нэрээр хуваарилан гаргасан байна.

Үүнд Баянхонгор аймагт 2016-2019 онд тусгай зөвшөөрлөөр хуваарийн дагуу 2016 онд 8 угалз, 8 тэх, 2017 онд 7 угалз, 15 тэх, 2018 онд 6 угалз, 15 тэх, 2019 онд 7 угалз, 19 тэх тус тус агнасан байна.

Хүснэгт № 02 Ангийн зөвшөөрлийн болон агнасан ангийн тоо

№	Сумын нэр	Тэх												Угалз											
		Зөвшөөрсөн тоо				Агнасан тоо				Зөрүү				Зөвшөөрсөн тоо				Агнасан тоо				Зөрүү			
		2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
1	Баацагаан	4	4	3	2	4	4	3	2	-	-	-	-	1	1	2	2	1	1	2	2	-	-	-	-
2	Баянбулаг				3				3	-	-	-	-									-	-	-	-
8	Баянцагаан		4	2	2		4	2	2	-	-	-	-	1	2	2	2	2	2	2	2	1	-	-	-
9	Богд									-	-	-	-	2	1	1		2	1	1		-	-	-	-
10	Бөмбөгөр			2	1			2	1	-	-	-	-									-	-	-	-
11	Бууцагаан			2	2			2	2	-	-	-	-									-	-	-	-
12	Галуут	2	3	2	2	2	3	2	2	-	-	-	-	1	1	1	1	1	1	1	1	-	-	-	-
14	Жаргалант			2	3			2	3	-	-	-	-									-	-	-	-
15	Жинст	2	3	2	2	2	3	2	2	-	-	-	-	2	1	1	1	2	1	1	1	-	-	-	-
16	Заг									-	-	-	-									-	-	-	-
17	Өлзийт		1		2		1		2	-	-	-	-	2	1		1	2	1		1	-	-	-	-
	Дүн	8	15	15	19	8	15	15	19	0	0	0	0	8	7	5	7	9	7	5	7	1	-	-	-

Дээрх хүснэгтээс харахад 2016 онд Баянцагаан сум 1 толгой угалз зөвшөөрлөөс илүү агнасан байна. Энэ талаар тус сумын байгаль орчны улсын байцаагчаас тодруулахад “*Лүүк Монголия ХХК нь Дорноговь аймгийн Хөвсгөл суманд агнах угалзын зөвшөөрөлтэй бөгөөд тус суманд ган болж ногоо гараагүйгээс агнах Угалз нь олдоогүй гэсэн шалтгаанаар Баянцагаан сумаас агнах хүсэлтийг БОАЖЯ-нд хүргүүлж, БОАЖЯ-ны сайдын тушаалаар тус сумаас агнасан болно*” гэсэн тайлбар өгсөн боловч БОАЖЯ-ны зөвшөөрөл олгосон шийдвэрийн нотлох баримтыг ирүүлээгүй болно.

Иймд дээрх Баянцагаан сумд агнасан 1 угалзын холбогдох зөвшөөрөл, баримт материалыг авч үзэн, шалгаж хариу мэдэгдэх албан шаардлагыг аймгийн МХГ-т хүргүүлэв.

Харин шонхор шувуу барих зөвшөөрлийг аймаг тус бүрээр тодорхой зааг ялгаатай тогтоогоогүй бөгөөд гадаадын иргэнтэй шонхор бариулах гэрээ



байгуулахдаа БОАЖЯ-ны албан тоот бичгээр аймгуудын нэр заасан бүс нутгаас шонхор барих зөвшөөрөл олгосон байна.

1.2.2. Амьтны тухай хуулийн 23.5 дахь заалтын дагуу Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор “Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ” болон “Ан амьтны нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамжийн хэмжээ”-г тогтоож, Засгийн газрын 2016 оны 155, 2017 оны 339 дүгээр тогтоолоор өөрчлөлт оруулсан байна.

Угалз, тэх, халиун бугын төлбөр болон хураамжийг дээрх тогтоолын дагуу ангийн төрлөөр, толгой тутамд америк доллароор тогтоож, тухайн үеийн Монгол банкны тухайн өдрийн ханшийг баримтлан тооцохоор заасан байна.

2016-2019 онд тусгай зөвшөөрлөөр агнах ангийн орлогыг экологи эдийн засгийн үнэлгээгээр тооцож, гүйцэтгэлтэй харьцуулан хүснэгтээр харуулав.

Хүснэгт №3. Ангийн орлогын тооцоолол, түүний гүйцэтгэл

№	Сумын нэр	2016 он			2017 он			2018 он			2019 он		
		Ангийн зөвшөөрөл	Гүйцэтгэл	Зөрүү	Ангийн зөвшөөрөл	Гүйцэтгэл	Зөрүү	Ангийн зөвшөөрөл	Гүйцэтгэл	Зөрүү	Ангийн зөвшөөрөл	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баацагаан	46.3	39.3	(7.0)	71.1	79.7	8.5	20.5	15.6	(4.9)	70.4	78.3	7.9
2	Баянбулаг	25.6	25.6	-	19.2	19.2	-	115.2	101.0	(14.2)	42.1	42.3	0.1
3	Баянговь	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
4	Баянлиг	12.8	12.8	-	-	-	-	-	-	-	-	-	-
5	Баян-Овоо	32.0	32.0	-	108.8	109.2	0.4	44.8	44.8	-	32.0	32.0	-
6	Баян-Өндөр	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
7	Баянхонгор	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
8	Баянцагаан	27.0	40.4	13.4	81.3	79.4	(1.9)	87.3	78.2	(9.1)	70.4	70.8	0.4
9	Богд	54.0	41.9	(12.1)	29.4	29.2	(0.2)	36.8	33.1	(3.7)	-	-	-
10	Бөмбөгөр	-	-	-	-	-	-	13.7	10.5	(3.1)	5.5	5.6	0.0
11	Бууцагаан	38.4	40.4	2.0	-	-	-	26.5	23.3	(3.1)	11.0	11.1	0.1
12	Галуут	120.6	107.7	(12.8)	71.9	75.7	3.8	54.7	53.3	(1.4)	73.1	80.7	7.7
13	Гурванбулаг	25.6	25.6	-	-	-	-	-	-	-	25.6	25.6	-
14	Жаргалант	-	0.0	0.0	32.0	33.1	1.1	13.7	10.3	(3.3)	16.5	18.4	1.9
15	Жинст	64.4	51.0	(13.3)	46.3	53.3	7.0	50.5	38.0	(12.5)	40.7	41.0	0.3
16	Заг	76.8	76.8	-	19.2	19.2	-	25.6	25.6	-	-	-	-
17	Өлзийт	86.0	81.0	(5.0)	54.2	57.8	3.6	25.6	25.6	-	66.3	67.9	1.6
18	Хүрээмарал	-	-	-	25.6	25.6	-	6.4	14.4	8.0	51.2	51.2	-
19	Шинэжинст	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
20	Эрдэнэцогт	44.8	44.8	-	19.2	19.2	-	-	-	-	-	-	-
	Дүн	654.2	619.3	(34.9)	578.3	600.7	22.4	521.3	473.9	(47.4)	504.9	524.9	20.0

Ангийн орлогын гүйцэтгэлээр нийт дүнгээр 2016 онд 34.9 сая төгрөг дутуу, 2017 онд 22.4 сая төгрөг илүү, 2018 онд 47.4 сая төгрөг дутуу, 2019 онд 20,0 сая төгрөг илүү нийт 124,7 сая төгрөгөөр зөрүүтэй тооцогдсон байна.

Гэвч тухайн үеийн гэрээ байхгүй, төлбөр тооцоо бодсон акт үйлдээгүй байгаагаас зөрүүтэй төлсөн эсэхийг аудитаар нотлох боломжгүй байна.



Иймд ангийн дээрх зөрүүтэй орлогын тооцоог гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй нийлж, гэрээг дүгнэн төсөв төвлөрөх орлогыг бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн БОАЖГ болон аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

Мөн ангийн гэрээ, төлбөр тооцоо хийсэн баримт, актыг архивын хадгаламжийн нэгж болгон тухайн сумдын ЗДТГ-т хүлээлгэн өгөхөд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт, сумдын байгаль орчны улсын байцаагч болон татварын улсын байцаагч нарын ажлын хариуцлагыг сайжруулан ажиллахыг аймгийн БОАЖГ-ын дарга болон Татварын хэлтсийн дарга нарт зөвлөмжөөр хүргүүлэв.

Баянхонгор аймагт 2016 онд 54, 2017 онд 62, 2018 онд 36, 2019 онд 29 шонхор тусгай зөвшөөрлөөр бариулж, бариулсан шонхор шувууны төлбөрийн орлогыг шонхор тутамд 6400,0 мянган төгрөгөөр тооцож, төвлөрүүлсэн байна.

Хүснэгт №4. Шонхор шувууны 2016-2019 онд барьсан тоо, төлбөрийн орлого.

д.д	сумын нэрс	Шонхорын тооцоо							
		Барьсан тоо, толгой				Төлсөн төлбөрийн орлого /сая.төг/			
		2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
1	Баацагаан	4	3			25.6	19.2	-	-
2	Баянбулаг	4	6	18	4	25.6	38.4	115.2	25.6
3	Баянлиг	2				12.8	0	0	0
3	Баян-Овоо	5	17	7	5	32.0	108.8	44.8	32.0
5	Бууцагаан	6		2		38.4	-	12.8	-
6	Галуут	13	4		4	83.2	25.6	-	25.6
7	Гурванбулаг	4			4	25.6	-	-	25.6
8	Жаргалант		5			-	32.0	-	-
9	Заг	12	3	4		76.8	19.2	25.6	-
10	Өлзийт	5	3	4	4	32.0	19.2	25.6	25.6
11	Хүрээмарал		4	1	8	-	25.6	6.4	51.2
12	Эрдэнэцогт	7	3			44.8	19.2	-	-
	Нийт	62	48	36	29	396.8	307.2	230.4	185.6

Харин БОАЖЯ-ны сайдын 2012 оны 08 сарын 10-ны өдрийн А-299 тушаалаар батлагдсан журмын 8.3²- дахь заалтыг орон нутагт бүрэн хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн хэмжээнд 2016-2019 онд нийт 167 шонхор шувуу бариулахад өгөөшөөр 1670 шувууны 48,7 сая төгрөгийн орлого оруулах боломж алдсан байна.

Хүснэгт № 5 Ангийн өгөөшний төлбөрийн судалгаа

д.д	Сумын нэр	Барьсан тоо, толгой					Өгөөшний тоо	шувуу /12 ам.дол/	Төлбөрийн дүн /мян.төг/	Төлсөн дүн /мян.төг/	Төлөөгүй дүн /мян.төг/
		2016	2017	2018	2019	дүн					
1	Өлзийт	5	3	4	4	16	160	1920	4,992.0	1,920.0	3,072.0
2	Баацагаан	4	3			7	70	840	2,184.0		2,184.0
3	Бууцагаан			2		2	20	240	624.0		624.0
4	Хүрээмарал		4	1	8	13	130	1560	4,056.0		4,056.0
5	Баянбулаг	4	6	18	4	32	320	3840	9,984.0		9,984.0
6	Гурванбулаг	4			4	8	80	960	2,496.0		2,496.0
7	Заг	12	3	4		19	190	2280	5,928.0		5,928.0

² “Нэг идлэг шонхор барихад өгөөш болгон ашиглах хөхвөр тагтаа болон ногтрууны тоо 10-аас илүүгүй байна”, 8.4-т “Өгөөш болгон ашиглах шувууны төлбөр хураамжийг Засгийн газрын 2011 оны 65 дугаар тогтоолын 2 дугаар хэсгийн 18-д заасан төлбөр хураамжийн хэмжээгээр буюу 12 ам доллароор тооцно”



8	Жаргалант		5		5	50	600	1,560.0		1,560.0
9	Галуут	13	4		4	21	210	2520	6,552.0	1,101.0
10	Баян-Овоо	5	17	7	5	34	340	4080	10,608.0	410.0
11	Эрдэнэцогт	7	3			10	100	1200	3,120.0	
	Дүн	54	48	36	29	167	1670	20040	52104.0	3,431.0
	1 ам.дол ханш /төгрөг/							2,600.00		

Цаашид Шонхор шувуу барихад өгөөшөөр ашигласан шувууны төлбөрийн орлогыг тухай бүрд нь тооцож бүрэн төвлөрүүлэх зөвлөмжийг БОАЖГ, МХГ, Татварын хэлтэс, Сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

1.3. Сумдын ЗДТГ нь Төрийн санд төвлөрсөн орлогын дүнгээр ангийн төлбөрийн орлогын тайланг татварт тайлагнасан байна.

1.3.1. Монгол улсын Засгийн газрын 2016 оны 155, 2011 оны 23, 2017 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан ан амьтны экологи эдийн засгийн үнэлгээ, үнэ тарифыг мөрдөж, тусгай зөвшөөрлөөр агнасан, барьсан ан амьтны төлбөрийн орлогыг сумын төрийн сангийн Агнуурын нөөцийн төлбөрийн орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Аудитаар Баянхонгор аймагт 2016-2019 онд тусгай зөвшөөрлөөр Угалз, Тэх, Халиун буга агнах агнуурын ажлыг Өлзийт, Галуут суманд 2016-2019 онд “Ажийн болор” ХХК, Богд суманд 2016 онд “САНДО” ХХК, 2017, 2018 онд Монгол Тур Рисорт” ХХК, Баянцагаан суманд 2016-2019 онд “Лүүк Монголиа” ХХК, Баацагаан, Жинст суманд 2016-2019 онд “Номадик Винд Трейвел” ХХК, Бөмбөгөр суманд 2018 онд “Саруул-Од Тур” ХХК, Бууцагаан суманд 2018 онд Саруул-Од Тур” ХХК тус тус гүйцэтгэсэн байна.

Тусгай зөвшөөрлөөр агнасан Угалз, Тэх, Халиун бугын төлбөр хураамжийн тооцоог 2016-2019 онд сум бүрээр тулган шалгахад Галуут сум 4133 ам.доллар, Өлзийт сум 1555 ам.доллар, Богд сум 4122 ам.доллар, Жинст сум 4201 ам.доллар тус тус дутуу төвлөрсөн, харин бусад сумын төлбөр, хураамжийн тооцоо тохирч байна.

Хүснэгт № 6. Зөрүү илэрсэн сумдын тооцоолол:

огноо	Үзүүлэлт	Галуут	Өлзийт	Богд	Жинст
2016	төлөх /ам.дол/	16,600	24,000	24,000	28,600
	төлсөн /ам.дол/	10,780	20,963	17,941	21,501
	зөрүү /ам.дол/	(5,820)	(3,037)	(6,059)	(7,099)
2017	төлөх /ам.дол/	18,900	14,300	12,000	18,900
	төлсөн /ам.дол/	20,587	15,782	11,964	21,798
	зөрүү /ам.дол/	1,687	1,482	(36)	2,898
2018	төлөх /ам.дол/	16,640	-	11,200	15,360
	төлсөн /ам.дол/	16,640	-	13,173	15,360
	зөрүү /ам.дол/	-	-	1,973	-
Нийт дүн	төлөх /ам.дол/	52,140	38,300	47,200	62,860
	төлсөн /ам.дол/	48,007	36,745	43,078	58,659
	зөрүү /ам.дол/	(4,133)	(1,555)	(4,122)	(4,201)

Дээрх зөрүүтэй орлогыг сум бүрийн байгаль орчны улсын байцаагч, санхүүгийн албаны дарга, Засаг дарга нараас тодруулахад тухайн үед нь тооцоо



нийлж, илүү, дутууг баталгаажуулж байгаагүйн улмаас тодорхой хариулт өгч, зөрүүг нотолж чадахгүй байна.

Иймд зөрүүг ан, агнуур хийсэн дээрх аж ахуйн нэгжүүдтэй тооцоо нийлж, зөрчлийг арилгуулах албан шаардлагыг сумдын Засаг дарга, санхүүгийн албаны дарга, байгаль орчны улсын байцаагч, татварын улсын байцаагч нарт хүргүүлэв.

1.3.2. Сумдын татварын байцаагч нар тусгай зөвшөөрлөөр агнасан ан амьтны төлбөрийг Засгийн газрын тогтоолоор тухайн ан амьтан бүрээр ам.доллараар тогтоосныг тухай үеийн Монгол банкны ханшаар тооцож ногдуулалт хийх байтал 2016-2019 онд амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын ногдуулалтыг зөвхөн төрийн сангийн дансанд орсон орлогын дүнгээр хийж тайлан гаргасан байна.

1.4 Ангийн төлбөрийн орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага албан тушаалтан хуулийн дагуу хяналт хэрэгжүүлээгүй байна.

1.4.1-2. Аймаг сумын ИТХ болон багийн ИНХ, Аймаг, сумдын болон багийн Засаг дарга нь нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16, 17 дугаар зүйлийн 1.1³ дэх заалтын хүрээнд тусгай зөвшөөрлөөр агнуулсан ангийн төлбөрийн орлогын гүйцэтгэлд хяналт хийгээгүй, харин аймгийн БОАЖГ, МХГ-аас ирүүлсэн хяналтын тайлангаас үзэхэд жил бүр аймгийн нутаг дэвсгэрт тарвага агналт, мод модон материалын тээвэрлэлт зэрэгт хяналт хийж байжээ.

1.4.3. Аймгийн Татварын байгууллагаас тусгай зөвшөөрлөөр агнуулсан ангийн төлбөрийн ногдуулалт, орлогын гүйцэтгэлд чиглэсэн хяналтыг хийгээгүй байна.

Иймд ангийн төлбөрийн орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумдын ИТХ болон ИНХ, аймгийн болон сумдын Засаг дарга нар, БОАЖГ, татварын хэлтэс, мэргэжлийн хяналтыг газарт зөвлөмжөөр хүргүүлэв.

БҮЛЭГ 2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн хэрэгжилт нь хуульд нийцэж байна уу?

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, төлбөр хураамж ногдуулах үйл явц нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд нийцэхгүй байна.

2.1 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах, төлбөр төлөхтэй холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлээгүй байна.

2.1.1. Аймгийн ИТХ-ын тогтоолоор аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталж байгаа бөгөөд 2019 онд хийгдсэн “Иргэн хуулийн этгээдэд

³ “нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих”



газар олголтын байдал, газар эзэмших, ашиглах гэрчилгээнд өөрчлөлт оруулах шийдвэр үйл ажиллагаа нь газрын тухай хуульд нийцсэн эсэх”-д хийсэн нийцлийн аудитын материалыг авч 2016-2019 онд аймгийн ИТХ-аар баталсан “Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө түүний биелэлтийг он тус бүрээр шалгахад түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгаагүй байгаа нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.1.1⁴ дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд цаашид “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг тусгаж Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 11.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

2.1.2. Аймгийн ИТХ-ын 2016-2019 оны тогтоолыг авч үзэхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай хэрэгцээнд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 11.1.2⁵ дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ талаар холбогдох мэргэжилтнээс тодруулахад “Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 60 тоот тогтоолоор нийтийн эдэлбэр газар, улс, аймгийн тусгай хамгаалалттай газар, ашигт малтмалын лицензтэй газраас бусад нутаг дэвсгэрийг тусгай хамгаалалтад авсан” гэсэн тайлбар өгөв. Гэвч түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг тусгай хэрэгцээнд авсан тогтоол гараагүй байна.

Иймд цаашид Газрын тухай хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргаж Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 11.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ИТХ-д хүргүүлэв.

2.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 18 хуулийн этгээдэд олгосон хэдий ч ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй нэг ч аж ахуйн нэгж байхгүй байгаа нь хууль зөрчигдөх гол шалтгаан болж байна.

2.1.1-2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлоход тусгай хэрэгцээний газрыг Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 13.1⁶-д заасны дагуу хамгийн түрүүнд өргөдөл гаргасан хуулийн этгээдийн материалыг хүлээн авч

⁴ 11.1.Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.1-д “аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон уурхайн талбайг тусгах”

⁵ 11.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын асуудлаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал доор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.2-д “Газрын тухай хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргах”

⁶ 13.1.Энэ хуулийн 6.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлд заасан шаардлага хангасан бөгөөд хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн хуулийн этгээдэд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгоно



Ашигт малтмал газрын тосны газарт хүргүүлж солбицлын давхцалгүй газарт зөвшөөрөл гаргуулж байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль 2014 онд батлагдсан бөгөөд түүнээс хойш хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоогүй байсан бөгөөд харин 2019 онд 18 газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг зохион байгуулсан байна.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгохдоо өргөдөл материалыг хүлээж авч материалыг ашигт малтмал, газрын тосны газарт хүргүүлж зөвшөөрөл авч, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдээр хэлэлцүүлсний үндсэн дээр аймгийн Засаг дарга захирамж гарган хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийг хүлээн авахдаа 250,0 мянган төгрөгийн тэмдэгтийн хураамжийг Төрийн сангийн 10003000941 тоот дансаар дамжуулан 4500.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Харин ашиглалтын тусгай зөвшөөрлийн ТТАМ-ын хуулийн 17.1⁷-т заасны дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж нь хайгуулын үр дүнд үндэслэн тусгай зөвшөөрөл хүсэх эрхтэй бөгөөд одоогийн байдлаар Баянхонгор аймгийн хэмжээнд нэг ч ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж, ахуйн нэгж байхгүй байна.

2.1.3. Сүүлийн жилүүдэд аймагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажил нэмэгдэж, түгээмэл тархацтай ашигт малтмалын хэрэгцээ шаардлага их байгаа нөхцөлд барилга байгууламжид ашиглаж буй ТТАМ-ыг ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй аж ахуйн нэгж байгууллага олборлож байгаа нь ТТАМ-ын тухай хуулийн 20.1.3⁸-д заасан заалтыг зөрчиж байна.

Иймд түгээмэл тархацтай ашигт малтмал борлуулах эрх бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу олгож, эрх бүхий этгээдтэй гэрээ байгуулан хуульд нийцүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогыг төлөвлөхдөө орон нутаг өрнөж байгаа бүтээн байгуулалтын талаарх суурь судалгааг хийлгүйгээр зөвхөн өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд суурьж байгаа нь бодитой бус байна.

2.3.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө дараах байдалтай байна.

⁷ Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбайд зөвхөн тухайн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргах эрхтэй.

⁸ 20.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч доор дурдсан эрх эдэлж, үүрэг хүлээнэ:


20.1.3. уурхайн эдэлбэрээс олборлосон бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмал, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн үнээр борлуулах;



ТТАМ-ын орлогыг төлөвлөж байгаа байдлыг сумдын ТЕЗ-ын төсвийн төслийг авч үзэхэд ТТАМ ашиглагч аж ахуйн нэгж байгууллагаар тооцсон тооцоо судалгаа, байгуулсан гэрээ байхгүй байна. Энэ талаар аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн орлогын мэргэжилтнээс тодруулахад: “өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлийн дунджаар төлөвлөдөг” гэсэн тайлбар өгсөн.

Мөн сумдад ТТАМ-ын төлбөрийн орлогыг хэрхэн төлөвлөж байгааг Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт сумдын төсвийн төлөвлөлтийг авч үзэхэд төлөвлөлт хийхдээ тооцоо судалгаа гаргаагүй, тоо хэмжээнд тулгуурлаагүй байна. Энэ талаар Санхүүгийн албаны дарга, татварын байцаагч нараас тодруулга авахад “Санхүү төрийн сангийн хэлтсээс төлбөрийн орлогыг шууд төлөвлөж өгдөг, бид тооцоолол хийдэггүй” гэсэн тайлбарыг өгөв.

Дүрслэл № 1 ТТАМ-ын төлбөрийн орлогын төлөвлөгөө



Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг төлөвлөхдөө аж, ахуйн нэгж байгууллагатай хийсэн гэрээ, орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын зураг, төсөв

зэрэг илэрхий байгаа тооцооллыг хийж төлөвлөхгүй байна.

Дээрх байдлаас харахад ТТАМ-ын төлбөрийн орлогыг бодитой төлөвлөхгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн “31.4.1⁹ гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд ТТАМ-ыг төлбөрийн орлогыг бодитой төлөвлөж, орон нутагт хийгдэж буй бүтээн байгуулалтын судалгааг гаргаж, хэрэгцээ шаардлагыг тооцож төлөвлөж байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

2.3.2. Аудитын дүн шинжилгээний горимын хүрээнд судалгаа хийхэд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2016 онд 8 барилга байгууламж 11.7 тэрбум, 2017 онд 8 барилга байгууламж 4.9 тэрбум, 2018 онд 17 барилга байгууламж 25.5 тэрбум, 2019 онд 26 барилга байгууламж 55,7 тэрбум төгрөгийн барилга байгууламж шинээр барих болон их засварт оруулахаар төлөвлөж, гүйцэтгэсэн байна.

⁹ “31.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана”
31.4.1 “Төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо”



Аудитын илрүүлэлт

УТХО-аар хийгдэж байгаа барилга байгууламж болон бусад иргэн, аж ахуйн нэгжүүдийн барилга барихад ашиглаж байгаа түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тооцоог хэрхэн тооцож ногдуулж буй талаар аймгийн Татварын хэлтсээс модруулахад тухайн барилга барьж байгаа газрууд нь аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй бетон зуурмагийн үйлдвэрүүдээс бетонон зуурмагийг худалдаж авч байгаа гэсэн тайлбар өгч байгаагаас үзэхэд түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийг хаанаас, хэнээс авах, татварын бааз сууриа мэдэхгүй байгаа зөрчил илэрлээ.

Дээрх судалгаанаас УТХО, ОНХС, хувийн хэвшлийн барилга байгууламжид шаардлагатай түгээмэл тархацтай ашигт малтмалын хэрэгцээг тооцож төлбөрийг тухайн сумын тогтоосон тарифаар тооцоолол хийхэд ойролцоогоор 2016 онд 19,1 сая, 2017 онд 18,1 сая, 2018 онд 114,1 сая, 2019 онд 76,9 сая нийт 228,2 сая төгрөгийн орлогыг дутуу ногдуулснаас төсөвт төвлөрөөгүй байна. / Тооцоололд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа блокны үйлдвэрлэл болон бусад хэрэгцээг оруулаагүй болно/

Хүснэгт № 6. Шаардлагатай ТТАМ-ыг орлогын тооцоолол /ойролцоогоор/

№	Сумын нэр	2016 он			2017 он			2018 он			2019 он		
		Шаардлагатай ТТАМ үнийн дүнгээр	Гүйцэтгэл	Зөрүү	Шаардлагатай ТТАМ үнийн дүнгээр	Гүйцэтгэл	Зөрүү	Шаардлагатай ТТАМ үнийн дүнгээр	Гүйцэтгэл	Зөрүү	Шаардлагатай ТТАМ үнийн дүнгээр	Гүйцэтгэл	Зөрүү
1	Баацагаан	0.0	1.1	1.1	0.0	0.5	0.5	0.0		-	0.5		(0.5)
2	Баянбулаг	0.8	0.2	(0.6)	0.0	0.3	0.3	0.0	0.1	0.1	2.2	0.3	(1.9)
3	Баянговь	0.7	0.1	(0.6)	0.0	0.2	0.2	0.7	0.7	(0.0)	0.7	0.4	(0.4)
4	Баянлиг	0.0	0.7	0.7	0.0	0.1	0.1	0.0		-	0.0		-
5	Баян-Овоо	0.0	0.1	0.1	0.0		-	0.0		-	1.5	1.1	(0.4)
6	Баян-Өндөр	0.0	0.1	0.1	0.0		-	0.0		-	0.0		-
7	Баянхонгор	0.0		-	0.0		-	15.4		(15.4)	0.0	0.1	0.1
8	Баянцагаан	0.0	0.1	0.1	1.0		(1.0)	0.0		-	2.6	0.3	(2.3)
9	Богд	0.0	0.1	0.1	0.0	0.3	0.3	0.7		(0.7)	1.8	2.4	0.6
10	Бөмбөгөр	0.6	0.1	(0.5)	0.0		-	0.0		-	0.0		-
11	Бууцагаан	0.0		-	0.0		-	0.0		-	0.7	0.3	(0.4)
12	Галуут	0.0	-	-	0.0	-	-	1.8	0.1	(1.6)	2.5	3.9	1.5
13	Гурванбулаг	0.0		-	0.0	0.0	0.0	0.7		(0.7)	0.0	0.8	0.8
14	Жаргалант	0.0		-	0.0	0.1	0.1	0.0	0.4	0.4	0.1	0.3	0.2
15	Жинст	0.0	1.0	1.0	0.0	0.2	0.2	3.7	0.4	(3.3)	2.7	1.0	(1.7)
16	Заг	0.0		-	0.0	0.0	0.0	0.0		-	0.6	0.4	(0.3)
17	Өлзийт	24.8	3.6	(21.2)	24.9	4.9	(20.0)	100.4	7.0	(93.4)	82.8	12.1	(70.7)
18	Хүрээмарал	0.0	0.1	0.1	0.0	0.1	0.1	0.0		-	0.9	-	(0.9)
19	Шинэжинст	0.0	0.1	0.1	1.4		(1.4)	0.0		-	1.5	0.7	(0.8)
20	Эрдэнэцогт	0.0	0.5	0.5	0.0	2.5	2.5	0.9	1.5	0.6	0.5	0.7	0.2
	Дүн	26.9	7.8	(19.1)	27.3	9.1	(18.1)	124.3	10.3	(114.1)	101.4	24.6	(76.8)

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд баригдах 53 барилга байгууламжийн ТТАМ-ын хэрэгцээг тооцож тухайн сумдын тогтоосон үнэ тарифаар тооцож үзэхэд ойролцоогоор 135.3 сая төгрөгийн орлого орохоор байна.

Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн ногдуулалтыг хуулийн дагуу ногдуулж байгаа эсэхийг тулган шалгахад сумд хэдий хэмжээний ашигт малтмал ашиглаж байгаа бүртгэл хяналт байхгүй атлаа төлбөрт төлсөн дүнгээс шууд хувь



тооцох байдлаар борлуулалтын орлогыг тооцож байгаа нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 33.2¹⁰-т заасан төлбөр нь олборлож худалдсан эсхүл ачуулсан бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувь байхаар заасан заалттай нийцэхгүй байна.

Өмнөх онуудын аудитаар аймгийн Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, БОАЖГ-т тус зөрчлүүдийг арилгах зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангалтгүй байгаа тул 2016-2019 онд зам, барилга угсралтын ажилд ашигласан ТТАМ-ын төлбөрийг тооцож төсөвт төвлөрүүлэх албан шаардлагыг аймгийн Татварын хэлтэс болон аймгийн БОАЖГазарт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийг зөрчсөн үйлдэлд хяналт шалгалт хийж хариуцлага тооцох албан шаардлагыг МХГазарт, цаашид орлогын ногдуулалт, бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т зөвлөмжөөр хүргүүлэв.

2.3.3. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 4 бетонон зуурмагийн үйлдвэр ажиллаж байгаа бөгөөд тухай аж, ахуйн нэгжүүд нь өөрсдөө тайланг цахимаар илгээж, ногдуулалтыг өөрсдөө тайлагнаж байна. Гэвч Татварын хэлтэс нь ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудад хэдий хэмжээний бетон үйлдвэрлэж, борлуулдаг, татварыг бүрэн үнэн зөв, ногдуулж буй эсэх, хэрэгжилтэд нь хяналт тавихгүй байгаа нь Татварын ерөнхий хуулийн 6.1.25¹¹-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Мөн сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байхгүй, ТТАМ ашиглаж байгаа этгээдтэй ихэнх сумд гэрээ байгуулаагүй, ногдуулсан тооцоо судалгаа байхгүй зэрэг хуулийг хэрэгжүүлээгүй нийтлэг зөрчил илрэв.

Хүснэгт № 6. ТТАМ-ын албан татварын биелэлт

он	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/	хувь
2016	18,2	9,6	52.7
2017	12,4	10,7	86.7
2018	12,0	10,5	87.9
2019	25,7	29,3	114.0
Дүн	68,3	60,1	88.1

ТТАМ-ын татварын тайланг сумын ЗДТГ мэдээлж байгаа ба аудитад хамрагдсан онуудад тайланг бүрэн мэдээлсэн боловч тайлангийн үзүүлэлтийг татварын орлогын гүйцэтгэлтэй тулгахад Баацагаан, Хүрээмарал, Богд,

¹⁰ 33.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нь олборлож худалдсан, эсхүл худалдахаар ачуулсан болон ашигласан бүх төрлийн түгээмэл тархацтай ашигт малтмалын бүтээгдэхүүний борлуулалтын үнэлгээний 2,5 хувьтай тэнцүү байна.

¹¹ 6.1.25. “татварын алба” гэж татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагч, хураагчийг;



Эрдэнэцогт, Галуут, Баянбулаг сумууд бүтээгдэхүүний хэмжээ болон нэгжийн үнийг зөрүүтэй мэдээлжээ.

Мөн Баянцагаан, Баян-Өндөр сумын татварын байцаагч нь ТТАМ-ын тайланг удаа дараа шаардсан боловч ирүүлээгүй тул Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу дээрх албан тушаалтнуудад хариуцлага тооцож ажиллахыг аймгийн Татварын хэлтсийн даргад зөвлөв.

Мөн байгуулсан гэрээ, ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалын тоо хэмжээнд хяналт тавьж, татварын тайланг үнэн зөв гаргуулж байх зөвлөмжийг аймгийн Татварын хэлтэст хүргүүлэв.

2.4. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох болон төлбөр төлөх үйл ажиллагаанд эрх бүхий байгууллага хяналт хэрэгжүүлээгүй байна.

2.4.1. Аймаг, сумдын ИТХ, Засаг даргаас ТТАМ ашиглах үйл ажиллагаанд 2016-2019 онуудад хяналт тавьж ажиллаагүй, зөрчил нийтлэг байгаа бөгөөд энэ нь Байгаль хамгаалах тухай хуулийн 16.1.1¹², 17.1.1¹³дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг аймаг сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт зөвлөмжөөр хүргүүлэв.

2.4.2. Аймгийн БОАЖГ болон МХГ-аас 2016-2019 онуудад ТТАМ-ын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн талаар тодруулахад түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр хяналт шалгалт хийгээгүй, уул уурхайн чиглэлээр хийгдэж байсан гэсэн тайлбарыг өгөв.

Энэ нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 10.2¹⁴-т заасан заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон ТТАМ хайх, ашиглах үйл ажиллагаанд хууль зөрчигдөж байгаа дээрх асуудалд хяналт тавьж ажиллахыг аймгийн БОАЖГ болон аймгийн МХГ-т албан шаардлагаар хүргүүлэв.

Харин Баян-Овоо сумын ЗДТГ-ын даргын 2019.05.07-ны өдрийн 19 тоот хяналт шалгалт хийх удирдамжаар Уран хайрхан 2 дугаар багийн нутагт байрладаг аймгийн төвийн нэгдсэн хогийн цэг 2010 онд байгуулагдсан хог хаягдлыг

¹² 16.1.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

16.1.1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

¹³ 17.1..Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал байгаль орчныг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1/нутаг дэвсгэртээ байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ, төсөв баталж, биелэлтэд хяналт тавих;

¹⁴ 10.2.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага гүйцэтгэнэ.



ландфилын аргаар дарж булшлах газар, хууль бусаар ТТАМ олборлож буй зөрчил түүнтэй холбоотой газрын нөхцөл байдлыг шалган ажиллах, Шанхай констракшн ХХК-ний 129 км улсын чанартай авто замын ажил хийгдэж тус сумын нутагт 67 км гүйцэтгэж байгаа компанийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийжээ.

Уг хяналт шалгалтаар 19 төрлийн зөрчил дутагдал илэрч байгаль орчны улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг тооцож ажилласан байна.

Аудитын илрүүлэлт

Аудитаар Эрдэнэцогт сумын БОХУБ болон татвар хураагч нартай хүрмэн чулууны ордод очиж газар дээр нь шалгахад 16 метр кубын багтаамжтай “Хово” автомашин зөвшөөрөлгүйгээр хүрэм ачиж байхтай таарав.

Тухайн иргэнтэй газар дээр нь ярилцлага хийхэд “Би энэ газраас байнга хүрэм авдаг авах бүртээ энэ ордыг хариуцдаг хүнд 180,0 мянган төгрөг өгдөг. Би хавар 4 сараас хойш 9 сар хүртэл блок үйлдвэрлэдэг. Хүрмээ байнга эндээс ирж авдаг. Авах болгондоо төлбөр төгрөг өгдөг, нэг ч удаа надад тасалбар олгож байгаагүй” гэсэн тайлбар өгсөн. Харин татвар хураагч нь “татварын ногдуулалтыг тухайн хүрэм хариуцдаг газартай тооцоо хийхдээ тасалбарт үндэслэн тооцоо хийдэг” гэсэн тайлбар өгч байлаа.

Дээрх байдлаас үзэхэд тухайн хүрмэн чулууны төлбөрийг төсөвт дутуу төвлөрүүлж байгаа нь харагдаж байна.

Мөн 2019 онд Баянхонгор аймгийн төвд баригдаж буй “Хөгжлийн хөтөч” хатуу хучилттай замын Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрт 10,0 сая төгрөгийг бэлнээр авч төсөвт төвлөрүүлэлгүй, зарцуулсан гэх мэдээллийг аймгийн Татварын хэлтсээс өгсөн боловч уг татвар нь аудитын явцад баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд Татварын байгууллага зөрчлийг мэдсэн атлаа чиг үүргийн хувьд арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Иймд Татварын ерөнхий хуулийн 6.1.25¹⁵-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ТТАМ-ын үйл ажиллагаа, тайлангийн үнэн зөв байдалд хяналт тавьж зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг Татварын хэлтэст хүргүүлэв.

бүлэг 3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хувь хэмжээгээр төлөвлөж, зарцуулж, тайлагнаж байна уу?

Аймгийн ТЕЗ нь Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хэмжээгээр төсөв баталж байгаа боловч холбогдох журамд заасны дагуу орлогын эх үүсвэрийг нөхөн сэргээхэд зарцуулагдахгүй байна.

¹⁵ 6.1.25. “татварын алба” гэж татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн татварын газар, хэлтэс, сумын татварын тасаг, татварын улсын байцаагч, хураагчийг;



3.1. Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг батлахдаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд заасан хувь хэмжээг баримтлахгүй байна.

3.1.1. Аймгийн БОАЖГ-ын 2016-2019 оны төсөвт байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төлөвлөхдөө Сангийн яамны хянасан ан, амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого, газрын нөөцийн төлбөрийн орлогын дүнгээс тооцож 2016 онд 104,5 сая, 2017 онд 105,5 сая, 2018 онд 205,5 сая, 2019 онд 233,8 сая төгрөг оруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт № 7. БОНСАХЗ-ыг Сангийн яаманд хянуулах үеийн орлого зардлын харьцаа / сая төг/

№	Орлогын нэр төрөл	2016			2017			2018			2019		
		Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь	Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь	Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь	Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	200.0	70.0	35	250.0	87.5	35	250.0	87.5	35	200.0	70.0	35
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	30.0	15.0	50	-	-	-	200.0	100.0	50	239.6	119.8	50
3	Газрын нөөцийн төлбөрийн орлого	130.0	19.5	15	120.0	18.0	15	120.0	18.0	15	160.0	24.0	15
4	Татварын хувь хэмжээ нэмэгдүүлсний зөрүү	-	-	-	-	-	-	-	-	-	-	20.0	-
	Дүн	360.0	104.5		370.0	105.5	28.5	570.0	205.5	36.1	599.6	233.8	39.0

Аудитын илрүүлэлт

Гэвч аймгийн ИТХ-аар төсөв батлах үед тооцоолол хийн СЯ-ны хянагдсан дүн дээр орлого нэмж тооцон төсвийн төлөвлөгөөг батлуулж байгаа бөгөөд уг нэмэгдсэн хэмжээгээр БОНСАХЗ-ыг нэмэгдүүлэхгүй байгаа нь Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1¹⁶ дэх заалт зөрчигдөж байна.

Хүснэгт №8. БОНСАХЗ-ыг төсөвт батлагдах үеийн орлого зардлын харьцаа / сая төг/

№	Орлогын нэр төрөл	2016			2017			2018			2019		
		Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь	Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь	Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь	Орлогын Төлөвлөгөө	БОНАХЗ төлөвлөгөө	Орлогод эзлэх хувь
1	Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого	410.0	70.0	17.1	405.9	87.5	21.6	400.0	87.5	21.9	253.3	70.0	27.6
2	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого	54.3	15.0	27.6	444.0	-	-	408.0	100.0	24.5	339.5	119.8	35.3
3	Газрын нөөцийн төлбөрийн орлого	130.0	19.5	15	120.0	18.0	15	124.0	18.0	14.5	270.0	24.0	8.9
4	Татварын хувь хэмжээ	-	-	-	-	-	-	-	-	-	-	20.0	-

¹⁶Энэ хуулийн 13.2-т заасан төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд тухайн төсвийн жилд зарцуулах хувь, хэмжээний доод хязгаарыг дараах байдлаар тогтооно: /Ан амьтны нөөц ашигласны 50%, Ус, рашааны нөөц ашигласны 35%, газрын төлбөрийн 15% г.м/



нэмэгдүүлсний зөрүү													
Дүн	594.3	104.5	59.7	969.9	105.5	36.6	932.0	205.5	60.9	862.8	233.8	71.8	

3.1.2. Дээрх төлөвлөлтөөс харахад Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын төлөвлөлтийг хийхдээ, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд тулгуурлан төлөвлөхгүй байна.

Иймд аймгийн ТЕЗ-ийн төсөв батлагдах үед БХНСАХЗ-д зарцуулах хувийг нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан заалтад нийцүүлэн батлуулж, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөөнд тулгуурлан төлөвлөж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-д хүргүүлэв.

3.2 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулагдаж буй хөрөнгийн зарим хэсэг нь зориулалт бусаар зарцуулагдсан байна.

3.2.1. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 2016-2019 онд 649,0 сая төгрөгийн 61 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан ба үүнээс 61 төсөл арга хэмжээнд 554,1 сая төгрөгийг зарцуулснаас 187,6 сая төгрөгийг журамд заасан байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулаагүй байна.

Хүснэгт № 8. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт

он	БОХНСАХЗ-ын төлөвлөгөө					БОХНС Зардал	Хувь	Зориулалтын дагуу			Зориу лалт бус
	Ангийн төлбөр	ой, ургамал	Усны төлбөр	Бусад	Дүн			ан	ой	Ус	
2016	8.0	37.0	10.0	49.5	104.5	78.8	0.1	8.5	31.5	10.0	28.8
2017	5.0	-	8.0	92.2	105.2	102.7	0.1	15.0	-	8.0	79.7
2018	60.0	15.0	66.0	64.5	205.5	174.4	0.1	59.2	10.0	62.6	37.6
2019	10.0	115.0	23.0	85.8	233.8	198.1	0.1	19.9	108.7	23.0	41.5
Нийт	83.0	167.0	107.0	292.0	649.0	554.1	85.4	102.6	150.2	103.6	187.6

Аудитын илрүүлэлт

Харин Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас зориулалт бусаар зарцуулсан нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “ Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 1.2.¹⁷ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Дөрвөн түмэн сарлагийн баярыг зохион байгуулахад 1.1 сая төгрөг
- Түүх соёлын дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газрууд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын мэдээллийг багтаасан газрын зураг хэвлүүлэх, аялал жуулчлалын цаглавар хийх, байгалийн үзэсгэлэнт газрыг тэмдэгжүүлэх 9.2 сая
- Иргэд, сурагчдын экологийн боловсрол дээшлүүлэх сургалт, эко аялал зохион байгуулахад 12.5 сая төгрөг
- Эвент арга хэмжээнд 9,5 сая төгрөг
- Орон нутагт аялал жуулчлалыг хөгжүүлэх 21 аймгийн уулзалт зөвлөгөөнд 6,2 сая төгрөг
- Байгаль хамгаалагч иргэн, иргэний нийгмийн байгууллага идэвхтнүүдийн зөвлөгөөн 3.5 сая төгрөг

¹⁷ “Байгалийн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна”



- Гар аргаар алт олборлоод орхисон талбайд нөхөн сэргээлт хийхэд 30.0 сая төгрөг
- Хуучин хогийн цэгийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад 15.0 сая төгрөг
- Сумдын мэдээллийн сан бүрдүүлэхэд 8.7 сая төгрөг
- Бие хамгаалах бороохой 30ш, дуран 15ш, зургийн аппарат, нормын хувцас 35ш авахад 18.9 сая төгрөг
- Говийн гайхамшиг 3-р зөвлөгөөн зохион байгуулахад 10.0 сая төгрөг
- Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэх, мэдээлэл сургалт сурталчилгаа уралдаан тэмцээн зохион байгуулахад 6.9 сая төгрөг
- Эрдэм шинжилгээний бага бага хурал хийхэд 4.5 сая төгрөг
- Байгаль хамгаалах нөхөрлөлүүдийн чуулган зохион байгуулах, идэвхтэн байгаль хамгаалагчдын дунд уралдаан зохион байгуулж урамшуулах 12.0 сая төгрөг
- Байгаль орчинд учруулсан хохирлын үнэлгээг тооцох 10.0 сая төгрөг гэх мэт

Иймд БОХНСАХЗ-ыг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасны зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

3.2.2. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний хүрээнд ан агнуурын бүс нутагт жил бүр тодорхой хэмжээний өвс, тэжээл, хужир тавьж өгсөн боловч үр дүнг нь тооцож гаргасан тайлан мэдээ байхгүй байна.

Мөн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төсвийг аймгийн БОАЖГ-ын төсөвт баталж байгаа нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.4¹⁸- дэх заалтыг зөрчиж байна.

Иймд Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг тухайн сумдын байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор тухайн сумдад нь хуваарилан баталж, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах.

Аудитаар Баянбулаг сумын ЗДТГ 2017 оны 12 дугаар сарын 22-нд байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас БОУБ-ийн албан ажлын хэрэгцээнд зориулж “Нармон” ХХК-руу мотоциклийн үнэ 1900,0 мянга, нормын хувцасны үнэ 600,0 мянган төгрөг шилжүүлсэн боловч одоо хүртэл уг хөрөнгийг орлого аваагүй төсвийн мөнгийг зүй бус зарцуулсан зөрчил илэрч төлбөрийн акт тогтоолоо.

3.3 Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд тавих хяналт хангалтгүй байна.

3.3.1. Аймаг сумдын ИТХ, багийн ИНХ-аас тусгай зөвшөөлөөр агнуулсан ангийн орлогоос ан агнуурын бүс нутгийн байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зориулж батлагдсан төсөв түүний хэрэгжилт буюу зэрлэг ан амьтны

¹⁸ амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогын хэсгийг энэхүү журмын 2.2.2-т заасны үндэслэн тухайн суманд зарцуулна



идэш тэжээл хомсдож буй бүс нутагт био техникийн арга хэмжээ авч амьдрах орчин нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд ан амьтдад хужир, шүү тавьж өгөх, биотехникийн арга хэмжээ авах ажлыг өвөлжилтийн байдал хүндэрч болзошгүй байгаатай холбогдуулан зориулж зарцуулсан зардал, түүний үр дүнд хяналт хийгдээгүй, зөвхөн уул уурхайн ашиглагдсан, эвдэрсэн талбайн нөхөн сэргээлт, булаг шандын орчин хамгаалах, ойн зурвас байгуулах чиглэлээр хяналт хийж байжээ.

3.3.2. Аймаг сумдын ИТХ, багийн ИНХ-аас тусгай зөвшөөлөөр агнуулсан ангийн орлогоос Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зориулж батлагдсан төсөв түүний хэрэгжилтэд зориулж хяналт хийгдээгүй байна.

Харин Хүрээмарал сум 2017 онд түгээмэл тархацтай хүрэм, хужир давсны орд газарт 4 удаагийн хяналт хийж давс олборлогч 8 иргэнтэй гэрээ байгуулж 14 тогоог нөхөн сэргээсэн гэж хяналт хийсэн ажлын тайланд дурьджээ.

3.3.3. Аймгийн БОАЖГ-аас 2016 оны 09 дүгээр сарын 07-12-ны өдрүүдэд байгаль орчны хяналтыг гүйцэтгэж, шалгалтын үр дүнд 8 сумын нутаг дэвсгэрээс хууль бусаар агнасан тарвага, бичиг баримтгүй буу 14ш-ийг хурааж, Жаргалант, Гурванбулаг, Баянбулаг сумдын нутгаас илрүүлсэн зөрчлийг байгаль орчны хяналтын улсын байцаагч нарт нь шилжүүлж Эрдэнэцогт сумын 1 иргэний хэргийг шийдвэрлүүлэхээр аймгийн Мэргэжлийн хяналтын газарт шилжүүлсэн байна.

Иргэдийн гомдол санал:

Аудитын явцад аймагт үйл ажиллагаа явуулж буй бетонон зуурмагийн үйлдвэрүүд нь хүнд даацын автомашинаар хайрга зөөвөрлөхдөө замыг их хэмжээгээр эвдэж, байгаль орчинд хохирол учруулж байгаа бөгөөд тухайн замд мотоциклтой иргэд осолдож байгаа талаар иргэдээс гомдол санал ирүүлсэн.

Үүнийг газар дээр нь үзэхэд газрын хөрс хүнд даацын машин явснаас эвдэгдсэн нотлогдож байна.

Иймд энэ талаар ажлын зураг авалт хийж, байгаль орчныг нөхөн сэргээх, байгаль орчинд нөлөөл нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн БОАЖГ-т албан шаардлагаар хүргүүлж, түгээмэл тархацтай ашигт малтмал зөөвөрлөх маршрутад хяналт тавьж ажиллах албан бичгийг аймгийн Цагдаагийн газар хүргүүлэв.

Аудитаар нийт 355,4 сая төгрөгийн 17 зөрчил илэрч, 2,5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 124,7 сая сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 7 албан тушаалтад 228.2 төгрөгийн зөрчлийг арилгах 15 заалт бүхий зөвлөмж хүргүүлэн ажиллав.



АУДИТЫН ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор аймгийн хөгжлийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигт байгалийн нөөц ашиглах талаар тусч байгаа бөгөөд хэрэгжилтийг тооцсон боловч тоо хэмжээний болон зарцуулсан зардлын гүйцэтгэлийг дүгнээгүй байна.
2. Аймгийн ИТХ-аас Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох талбайг тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргаагүй, аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаагүй байна.
3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөрийн орлогыг төлөвлөхдөө орон нутаг өрнөж байгаа бүтээн байгуулалтын талаар судалгаа хийхгүйгээр зөвхөн өмнөх онуудын татварын орлогын гүйцэтгэлд суурьж байгаа нь бодитой бус байгааг төлбөрийн орлого бүрэн төвлөрөхгүй байна.
4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг 18 хуулийн этгээдэд олгосон хэдий ч ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байхгүйгээс Түгээмэл тархацтай ашигт малтмалын хуулийг зөрчин олборлолт хийж байна.
5. Ангийн төлбөрийн орлогын ногдуулалтыг хийсэн акт үйлдэж тооцоо нийлээгүйгээс орлогын зөрүүг аудитаар нотлох боломжгүй, зарим сумд холбогдох баримт бичгийг архивын нэгж үүсгээгүй байна.
6. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах зардлын төсвийг аймгийн БОАЖГ-ын төсөвт баталж байгаа нь Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журмын 3.4 - дэх заалтыг зөрчиж байна.
7. Аймгийн Татварын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газрууд нь эрсдэлд суурилсан хяналт хийдэг гэх боловч ан агнах, Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлохтой холбоотой илт хууль зөрчсөн удаан хугацаанд үргэлжилсэн зөрчилтэй асуудал нь эрсдэлийн гадна үлдсэн байна.
8. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хуульд заасан хэмжээгээр төсөв батлаагүй, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг зөрчин батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ



АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

НЭГ. АЙМГИЙН ИТХ-ЫН ДАРГА Ц.ОТГОНБАЯР ТАНАА:

1. “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-нд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын талбайг тусгаж, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 11.1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.
2. Газрын тухай хуульд заасны дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай, ордод хамаарч байгаа газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргаж, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай 11.1.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

ХОЁР. АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Г.БАТЖАРГАЛ ТАНАА:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлож буй аж, ахуйн нэгж байгууллагад хуульд заасан шаардлагын дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах.
2. Ан, агнах болон түгээмэл тархацтай ашигт малтмалын үйл ажиллагаанд тавьж буй хяналтыг сайжруулан холбогдох хэлтэс агентлагийн дарга нарын ажлын үр дүнг хэлэлцэж байх.
3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд хяналт тавьж байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

ГУРАВ.: АЙМГИЙН ЗДТГ-ЫН СТСХ-ИЙН ДАРГА С.БАЙГАЛМАА ТАНАА

1. ТЕЗ-ийн төсвийн төлөвлөлтийн материалыг иж бүрэн гаргаж, архивын нэгж үүсгэж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.
2. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг байгалийн нөөцийг хамгаалах зорилгоор тухайн сумдад нь хуваарилан баталж, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллах.
3. БХНСАХЗ-ыг Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журамд заасны зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

ДӨРӨВ. АЙМГИЙН ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГА С.РЭНЦЭНДАГВА ТАНАА:

1. Ангийн төлбөрийн орлогын гүйцэтгэлд тавих хяналтыг хэрэгжүүлж, ан агнасан тухай бүрд нь гэрээгээр үүрэг хүлээж буй этгээдтэй төлбөрийн тооцоог нийлж, сумдын байцаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах.
2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг ашиглаж байгаа зам, барилгын компаниудтай хийх тооцоог цаг тухай бүрд нь хийж, Шонхорын өгөөшний орлогыг бүрэн тооцон төвлөрүүлж, Татварын ерөнхий хуулийн 6.1.25 -т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж



3. Татварын ерөнхий хуулийн 6.1.25 -т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ТТАМ-ын үйл ажиллагаа, тайлангийн үнэн зөв байдалд хяналт тавьж, зөрчилд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах.

ТАВ. АЙМГИЙН БОАЖГ-ЫН ДАРГА БАТ-ӨЛЗИЙ ТАНАА:

1. Ан, агнуурын гэрээ болон агнасан актыг тухай бүр бүрдүүлж, шонхор шувуу барихад өгөөшөөр ашигласан шувууны төлбөрийг тухай бүрд нь тооцож бүрэн төвлөрүүлэхэд Татварын байгууллагатай хамтлан ажиллаж, ажлын хариуцлагыг сайжруулж ажиллах.
2. Хууль зөрчин Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй олборлолт хийж буй этгээдэд хяналт тавьж зөрчлийг арилгах.

ЗУРГАА. АЙМГИЙН МХГ-ЫН ДАРГА БЯМБАДОРЖ ТАНАА:

1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөлгүй хууль зөрчин олборлолт хийж буй этгээдэд хяналт тавьж хуульд заасан арга хэмжээг тооцож ажиллах.
2. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж буй бетонон зуурмагийн үйлдвэрүүдийн хайрга зөөх үйл явцад хяналт хийн, авто зам, байгаль орчинд нөлөөлж байгаа нөлөөллийг тооцож байгаль орчинд учруулж буй хохирлыг багасгаж, учруулсан хохирлын төлбөрийг тооцож ажиллах.

ДОЛОО. СУМДЫН ИТХ-ЫН ДАРГА, ЗАСАГ ДАРГА НАРТ:

1. Ангийн болон түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогыг бодитой тооцож төлөвлөж байх.
2. Ангийн гэрээ, төлбөр тооцоо хийсэн баримт материал, ан агнуурын актыг архивын хадгаламжийн нэгж болгон сумын ЗДТГ-т хүлээлгэн өгөхөд хяналт тавьж ажиллах.
3. Ангийн төлбөрийн орлого болон Шонхор шувуу барихад өгөөшөөр ашигласан шувууны төлбөрийг тухай бүрд нь тооцож бүрэн төвлөрүүлэх.
4. Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, орлогыг бүрэн төвлөрүүлж байх.

Зөвлөмжийн мөрөөр зохиосон ажил, түүний хэрэгжилт, үр дүнг 2020 оны 11 дүгээр сарын 20-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ